



## ЭМГЭНЭЛ

ХОНОСБАЙН ЕДИЛХАН

(1956-2022)

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Баян-Өлгий аймаг дахь салбарын ахмад ажилтан, доктор Хоносбай овогтой Едилхан 2022 оны 11-р сарын 03-ны өдөр таалал төгсөж хүнд гарз тохиолоо.

Х.Едилхан нь 1956 онд Баян-Өлгий аймгийн Алтай сумын нутаг “Харбут” хэмээх газар төрсөн. Тэрээр 1964-1972 онд Алтай сумын 8 жилийн дунд сургууль, 1972-1974 онд Өлгий сумын 2-р 10 жилийн сургуулийг дүүргэж, 1978 онд ХААДС-

ийг нягтлан бодогч мэргэжил эзэмшин 2001 онд ХААИС-д магистр, 2007 онд МУИС-д Түүхийн ухааны доктор (Ph.D) зэрэг хамгаалсан. Тэрээр 1978-1982 онд Баян-Өлгий аймгийн Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргаанд мэргэжилтэн, 1982-1988 онд Нийтийн аж ахуйн үйлчилгээний газарт эдийн засагч, 1988-1992 онд аймгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх захиргаанд мэргэжилтэн, 1992-1996 онд Усны аж ахуйн газарт нягтлан бодогч, 1996-2003 онд “Алтай тур” компанид менежер, 2003-2011 онд ШУА-ийн Баян-Өлгий аймаг дахь Нийгэм, эдийн засгийн судалгааны төвд Эрдэм шинжилгээний ажилтан, 2011-2016 онд Ховд Их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуульд захирал, дэд захирлын ажлыг үр бүтээлтэй гүйцэтгэсэн.

2000 оноос Монгол Алтайн нурууны түүх, археологийн дурсгалыг судлах 10 гаруй экспедицэд оролцож, тус аймгийн нутаг дэвсгэрээс нэлээд олон түүхэн дурсгалыг шинээр илрүүлэн он цаг болон газар зүйн байршлыг тодруулан тодорхойлсон. Тэрээр “Монгол Алтайн хадны зургийн судалгааны зарим асуудал” нэгэн сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүллийг гадаад, дотоодын мэргэжлийн сэтгүүлүүдэд хэвлүүлснээс гадна, 20 гаруй аяллын маршрутыг боловсруулж, бүс нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулсан юм.

2008-2011 онд “ЮНЕСКО-ийн баримт бичиг боловсруулах” судалгааны багт ажиллаж, эрдэмтэдтэй хамтран Дэлхийн биет бус соёлын өвийн жагсаалтад Монголын казахуудын бүргэдээр ан хийх соёлын өв болон “Шивээт хайрхан”, “Арал толгой”, “Цагаан салаа”, “Бага-Ойгор”-ын хадны зургийн цогцолбор дурсгалуудыг “Монгол Алтайн хадны зургийн цогцолбор дурсгал” нэрээр бүртгүүлэх, Монголын казахуудын соёлын өвийг дэлхийд таниулах, хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулжээ. Түүний хөдөлмөр зүтгэлийг өндрөөр үнэлж, төр засгаас 2010 онд Алтан гадас одон, 2011 онд Шинжлэх ухааны тэргүүний ажилтан, 2017 онд Аялал жуулчлалын тэргүүний ажилтан цол, тэмдгүүдээр шагнасан байна.

Талийгаачийн хүнлэг сэтгэл, төлөв даруу, нөхөрсөг, уйгагүй хөдөлмөрч, өв соёлоо эрхэмлэдэг зан чанар бидний зүрх сэтгэлд мөнх орших болно.

ШУА-ИЙН ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН  
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР